

ПОПУЛИСТ ҮЙЛДИЙН АГУУЛГА, МӨН ЧАНАР

POPULIST ACTIONS: CONTENT AND FEATURE

**Д.БАТЦЭЦЭГ**

Хууль сахиулахын их сургуулийн Эрх зүй, нийгмийн ухааны сургуулийн
Нийгмийн ухааны тэнхимийн ахлах багш, цагдаагийн ахмад

BATTSETSEG D.

Senior lecturer of Faculty of Social Sciences,
Institute of Law and Social sciences, Police captain

Товч агуулга: Өнөөдөр Монголын нийгмийн амьдралд улс төрийн сонирхдоггүй, улс төрийн тодорхой асуудлаар өөрийн үзэл бодлыг илэрхийлдэггүй бие хүн бараг байхгүй болжээ. Үүнтэй зэрэгцээд улс төрийн амьдралд “популизм” гэдэг нэр томъёо хүчтэй түрэн орж ирж байна. Иймээс ардчилсан нийгэмд иргэн бүр улс төрийн үйл ажиллагаанд ямар нэгэн хэмжээгээр гар бие оролцдогийн хувьд “Улс төрийн популизм” хэмээх энэхүү ойлголтын талаар тодорхой хэмжээний мэдлэгтэй байх шаардлагын үүднээс энэхүү онолын мэдээллийг Та бүхэнд хүргэж байна. Энэ өгүүлэлдээ улс төрийн популизмын талаарх ойлголт, түүний талаарх эрдэмтдийн тайлбар, популист үйлдэл нийгмийн амьдралд илрэн гарах хэлбэр, улс төрчид популизмыг үйл ажиллагаандаа хэрхэн ашигладаг талаарх мэдээллийг оруулахыг зорьлоо.

Abstract: Today, in Mongolian society, there is no one who isn't interested in politics and doesn't represent their points of view in any political issues. At the same time, the term “Populism” is invasively coming into politics and society.

In democratic society, everyone involves in the political activities. So there is an urgent need to obtain some knowledge about this concept of «Political populism».

On the basis of above situation, in this article, we focused on including concept of political populism, its theory, scientific explanations, its populist actions manifested in social life and information of how politicians use it.

Түлхүүр үгс: Популизм, популист үйлдэл, популизмын зарчим, популизмын арга, үндэсний популизм, ард түмэн.

Key words: Populism, populist action, principles of populism, ways of operating populism, national populism, mass

Өнөөдөр Монголын нийгмийн амьдралд улс төрийг сонирхдоггүй, улс төрийн тодорхой асуудлаар өөрийн үзэл бодлыг илэрхийлдэггүй бие хүн бараг байхгүй болжээ. Үүнтэй зэрэгцээд улс төрийн амьдралд “популизм” гэдэг нэр томъёо хүчтэй түрэн орж ирж байгаа нь ажиглагдаж эхэллээ. Энэ нь өнөөдрийн Монголын улс төрийн амьдрал, нийгмийн тогтолцоо нь шилжилтийн шинж чанарыг агуулж

байгаатай холбоотой ажээ. Өөрөөр хэлбэл, барууны орнуудын улс төр судлаачдын судалгаа шинжилгээ нь шилжилтийн үеийн нийгэмд популизм хамгийн хурцаар илэрдгийг хэдийн баталсан байна.

Улс төр судлаач эрдэмтдийн популизмын талаар гаргаж байгаа тодорхойлолт, үзэл бодлуудаас харахад ихэнх тохиолдолд эдийн засгийн хүчин зүйл дээр суурилсан тайлбаруудыг



Хууль сахиулах
үйлс

олонх нь хийх болжээ. Тиймээс миний бие судлаачийн хувиар юун түрүүнд өөрийн үзэл бодлоо илэрхийлэхээс өмнө “Улс төрийн популизм” хэмээх энэхүү нэр томъёоны онолын тайлбар, агуулгыг уншигчдад ойлгуулахын илүүд үзлээ.

Юуны өмнө популизм хэмээх ойлголтын тухай- Популизм гэдэг нэр томъёо нь латины *populus* буюу ард түмэн гэсэн үгнээс гаралтай бөгөөд анх XIX зууны сүүлч үеэс Америкийн Нэгдсэн улсын улс төрийн амьдралд хэрэглэгдэж эхэлсэн гэж үздэг.

Түүхээс сөхөн үзвэл:

1969 онд Лондоны Эдийн засгийн сургуулиас популизмын асуудлаар эрдэм шинжилгээний хурлыг зохион байгуулсан бөгөөд хуралд оролцсон нийгэм судлаач эрдэмтэд “Хий үзэгдэл, популизмын хий үзэгдэл ертөнцөөр тэнэж байна” гэж тэмдэглэжээ. Тэд энэ хий үзэгдэл шиг шинж чанарыг нь улам тодруулж байх мэт “хэн ч үүнийг яг юу юм бэ гэдгийг төсөөлж чадахгүй, түүний агуулга тодорхойгүй бөгөөд тодорхойлогдох боломжгүй илрэх хэлбэрээ өөрчилж байдаг” гэж дүгнээд энэхүү үзэгдлийн агуулга мөн чанар нь үл ойлгогдох хэвээр үлдэж байгааг онцлон тэмдэглэсэн байдаг. Энэ хуралд А.Турэн, И.Берлин, Л.Шапиро, А.Валицки, Д.Макрэ, Ж.ф.Манчини, Х.Сегон-Уотсон зэрэг томоохон судлаачид оролцжээ. Тэд “Популизм гэдэг нь хичнээн олон дүр хэлбэрт хувилж шингэсэн ч нэг л үзэгдэл эсвэл өөр хоорондоо ялгаатай агуулга хүрээнд буруу хэрэглэгддэг зүгээр л нэг нэр томъёо” гэсэн дүгнэлтэд эцсийн дүндээ хүрэх боломжийг олгож байгаа 6 үндсэн асуудлыг хурал дээр тодруулсан байдаг. Үүнд:

1. Популизм нь үзэл суртал юмуу, хөдөлгөөн юмуу эсвэл аль аль нь юмуу гэдэгт оршиж байв.

2. Магадгүй популизм бол нийгмийн хөгжлийн голлох хүчин зүйлүүд байхгүй завсрын үе эсвэл хэтэрхий сул байх нийгмийн онцгой

нөхцөл байдал үүссэний үр дүнд төрөл бүрийн түүхэн болон газар зүйн нөхцөлүүдэд илэрдэг, байнгын сэргэн төрж байдаг сэтгэлгээний төрөл байж болох юм.

3. Популизмыг улс төрийн сэтгэл зүйн нэр томъёонуудад тодорхойлж болох юм. Ард түмний эсрэг гарцаагүй нууц хуйвалдаан шаргуу зорилго чиглэлтэйгээр сүлжилдэж оршиж байна гэсэн мэдрэмж популизмд нэвт шингэсэн байдаг.

4. Популизмын гол чиглэл бол олон улсын харилцаа, банкны эзэд, капиталыг эзэмшигчдийн талаарх эсвэл үл мэдэгдэх гадаад хүчний талаар сэжиглэх сэжиг юм. Популизм нь өвөрмөц үгүйсгэл, сөрөг үзлээр тодорхойлогддог буюу тэр чигээрээ “анти” үзэл юм. Эсрэг: капитализмын эсрэг, хотжилтын эсрэг, нүүдэллэн суурьшигчдын эсрэг, айдас, сэжгээр нэвт шингэсэн байдаг.

5. Популистууд ард түмнийг шүтэн биширдэг. Гэвч популистуудын бурхан мэтээр шүтэж байгаа ард түмэн нь заавал сул, дорой, азгүй, хувь тавилангүй байх ёстой гэж үздэг. Ард түмэн хичнээн хэмжээгээр ядуу зүдүү, сул дорой байх тусам төдий хэмжээгээр популистууд тэднийг бурхан адил шүтнэ.

6. Эцэст нь, энэ бол түүхэн судалгаанаас үзэхэд илүү тогтвортой үзэл суртал бөгөөд нийгмийн хөдөлгөөнд уусч алга болж, дахин сэргэн гарч ирдэг үзэгдэл юм. Популизм гэдэг үгийг улс төрд төлөв байдлын сөрөг үр дүн мэтээр ашигладаг. Популизмыг улс төр, социологийн судалгаан дахь шинжлэх ухааны ойлголт гэж үзэхэд нэлээд эргэлзээтэй. Улс төрийн шинжлэх ухааны толь бичигт популизмыг «Олон түмэнд үндэслэлгүй амлалт өгч, хуурмаг уриа лоозон дэвшүүлснээр өөрийн зорилгыг хангаж нэр алдарт хүрэх үйл ажиллагаа» гэж тодорхойлсон байдаг.

Харин хуурмаг яриа (демагогия) гэдэг нь үйл явцыг зориуд санаатайгаар



гажуудуулах заль мэх, хуурмаг амлалт гэж тодорхойлогдсон байдаг. Энгэхээр, «популизм» «демагогия» гэдэг хоёр ухагдахуун нь үндсэндээ ойролцоо үгнүүд юм. Гэхдээ эдгээр нь шинжлэх ухааны ойлголт болж чаддаггүй. Мэдээж, үндэслэлгүй амлалт гэж шинжлэх ухааны үзэл баримтлал гэж юу байх вэ дээ?

Нийгмийн болон эдийн засгийн хөгжлийн олон үзэл баримтлалд үндэслэлтэй ба үндэслэлгүй гэсэн адил амлалтыг гаргаж болох талтай.

Улс төр дэх тэмцэл болон олон түмний санаа бодолд хүрэхийн тулд популизмыг ашигладаг.

Хосе Ортега-и-Гассет «Дэлхий дээр ямар ч засаглал нийтийн санаа бодлоос өөр юунд ч суурилагдаж байгаагүй. ...Ихэнх хүмүүст улс төрийн талаар өөрийн санаа бодол гэж байдаггүй. Иймээс, машины моторт тос масло түрхэж байж ажилд оруулдаг шиг хүмүүсийг санаа бодолд нөлөөлөх замаар улс төрийн талаарх үзэл бодлыг нь бий болгох хэрэгтэй» хэмээн хэлсэн байдаг.

Аливаа улс төрийн үзэл баримтлал нь түүнийг хэрэглэгчдийн зах зээлээс шууд хамаардаг. Энэхүү үзэл баримтлалын үндсэн үзэл санаа нь хүн амын олонхд ойлгомжтой байх ёстой. Өөрөөр хэлбэл, энэ нь улс төрийн мэдлэгийн хүрээнд хэрхэн хүлээн авагдаж байгаагаас шууд хамаарна гэсэн үг юм.

Энэхүү шалтгааны улмаас XIX зууны сүүлчийн хагаст ихэнх улсад популизм гэдэг нэр томъёо гарч ирсэн нь тохиолдлын зүйл биш юм.

Популизмын урсгал зөвхөн улс төрд ч биш бас урлагт байжээ. Жишээ нь: XX зууны Францын популизм ядуу, энгийн хүмүүсийн амьдралыг бодит байдлаар дүгнэлт хийхийг шаарддаг байжээ. Энэ хөдөлгөөн нь натурализмын ямар нэг төрөл хэлбэрийг бий болгож болно.

XIX зууны үеийн популистууд өөрсдийн шаардлага нь биелсэн тохиолдолд үнэн шударга байдалд хүрнэ

гэж үнэн голоосоо итгэдэг байсан бол XX зууны үеийн популистууд өөрсдийн шаардлагаа гаргахдаа иргэдийн эрх ашигт өчүүхэн ч санаа тавьдаггүй байсан байна. Тэдний шаардлага биелснээр ихэнх иргэдийн байдлыг дордуулахад хүргэсэн юм.

Хууль тогтоох болон гүйцэтгэх байгууллагын популизм зөвхөн хэлбэрээрээ ялгардаг. Гүйцэтгэх засаглал иргэдийн эрх ашгийг хамгаалах, үндэсний валютыг чангатгах, эх орны аж үйлдвэрийг хөгжүүлэх зэрэг асуудлыг тунхаглаж байдаг ч явуулж буй улс төрийн бодлого нь уг эрх ашгуудыг хавчсан шинж чанартай байдаг.

Сүүлийн жилүүдийн иргэдийн нийгэм судлал, улс төрчдөд итгэх итгэл нь улам буурсаар буйг олон талт судалгаануудаас харж болно. Итгэл нь тийм түвшинд (хэмжээнд) байхад иргэдийн үзүүлэх улс төрийн дэмжлэг нь бараг үгүй болно.

Ийм нөхцөлүүдэд улс төрчид популизмыг энэ хөндийрсөн байдлын хаалт болгон ашиглаж, улс төрийн элитийн үйл ажиллагааны дүрэм болгож байна. Иргэд засаглалаас хөндийрсөн нь улс төрийн үйл явцын гол үндэс болж, түүний нэг хэлбэрт нь популизм орно.

Популизмыг улс төрийн үйл ажиллагааны нэгэн төлөв байдал болгож үзнэ. Популизм нь ямар нэгэн хэмжээгээр улс төрчдийн үйл ажиллагаанд зайлшгүй оролцдог. Популизмын нэг хэлбэр нь ямар ч асуудлыг хялбар болгож, түүнийг бүгдэд ойлгомжтой, дөхөмтэй хүргэхэд оршино.

Улс төр дэх популистуудын хоёр дахь шинж чанар нь улс төрийн лидерүүдийн явуулж буй үйл ажиллагаа болно. Тэд иргэдийн сонирхолд нийцсэн ухамсартай зохион байгуулалтыг бий болгоход анхаарал тавихгүй, харин уг лидерүүдтэй иргэдийг шууд холбоо тогтоох үйл ажиллагааг явуулж байна. Энэ нь нол төлөв улс төрчид зөвхөн


сонгогч болон иргэдэд нөлөө үзүүлэхийг хичээдэг байдлаар илэрдэг буюу тухайлбал, сонгуулийн явцад улс төрчид иргэддээ биелэшгүй амлалт өгч, сонгогдсоны дараа ч бодит шийдвэр гаргахын оронд иргэдээ хуурсаар байдагт оршино.

Популизм нь улс төрчдийн нийгмийн корпусын нэгэн шинж гэж хэлж болно. Шинэчлэлийн явцад ихэнх иргэдийн амьдрал нь доройтож, нийгмийн дунд хүчтэй анги бүлэг үүсдэг. Шинэ нөхцөлд дасах хэцүү учраас амьдралын гол асуудлуудад хариу авах хүсэл иргэдэд төрдөг. Энэ бүхэн дээр дөрөөлөн популизмын нөлөөллийг ашиглах, түүнийг хөгжүүлэх боломжийг улс төрчид бий болгодог байна. Тэд иргэдэд тулгамдсан асуудлыг шийдвэрлэх хялбар шийдвэрийг санал болгож эхэлдэг.

Бодит улс төрийн тавцан дээр иргэдийн засаглалаас хөндийрөх үйл явц нь улс төрийн популизмаар далдлагддаг.

Популизм нь улс төрийн зан байдлын хэлбэр бөгөөд уг хэлбэр нь олон нийттэй шууд харилцаа тогтоох, тэдний дэмжлэгийг авахын тулд тэдэнтэй явуулдаг нэгэн төрлийн тоглоом юм.

Онолын хувьд популизмыг дараах зарчмуудаар тодорхойлох боломжтой. Өөрөөр хэлбэл, та бидний улс төрийн тавцангаас популизм хэмээн ойлгож, олж хардаг улс төрийн үзэгдэл үйл явцад үнэлэлт өгөхдөө дараах зарчмын шинжтэй ойлголтууд илэрч байна уу гэдгээс нь хамаарч үнэхээр улс төрийн популизм мөн үү, үгүй юу гэдгийг тодорхойлоорой.





МОНГОЛ
УЛСЫН
ХУУЛЬ
САХИУЛАХ
УРСАЛ

Улс төрийн тавцанд өөрийн гэсэн байр суурийг тогтоохдоо ард түмнийг ашиглах явцдаа дийлэнх популистууд дараах арга хэрэгслийг ашигладаг байна.

Популист аргууд	
Ард түмний шаардлага, хэрэгцээг ашиглах оролдлого	Энгийн, сүртэй уриа лоозонд олон түмэн амархан автдагийг ашиглах
Олон түмний энгийн ухамсрын шинж чанарыг ашиглах, нийгмийн амьдралын талаарх төсөөллийг хялбаршуулах, шулуун ойлголт, максимализм, бие хүнд татагдах	Ард түмний “хүлээлт” дээр тоглох
Санал болгож байгаа асуудлын энгийн ойлгомжтой байгаагаар далимдуулах, нарийн асуудлыг энгийнээр шийдвэрлэхийг чухалчлах	Улс төрийн институт, байгууллагаар дамжуулалгүй удирдагч лидер ба олон түмний хооронд шууд холбоо тогтоох
Хямралаас гарах хамгийн хурдан, хамгийн хялбар арга замд итгэх хүмүүсийн итгэл дээр тоглох	Жирийн ард түмний төлөөлөгч, жирийн хүний нэрийн өмнөөс үг хэлэх
Хүмүүсийг оршин буй засаглал, элитүүдийн эсрэг уур гомдолд хандлагдажуулах	Олонхийн анхаарлын төвд үргэлж байхын тулд тухайн үед байгаа хамгийн тулгамдсан асуудлуудын шийдвэрлэгдээгүй байдлыг ашиглах
Хамтын санаа бодол зөвшилцөлтэй сөргүүлж хувийн эрх чөлөө ёс суртахуунд хандах	Олон нийтийн санаа бодлыг санаан зоргоор удирдах, чиглүүлэх, тоглох

Популист улс төрчийн хэв маяг

Улс төрийн популизмыг үйлдэх арга хэрэгслүүд олон янз, баримтлах зарчмууд нь мөн адил олон янз байхын хэрээр төрөн гарч буй популист улс төрчдийн өөрсөддөө бүтээсэн дүр төрх нь хүртэл олон янз байдаг. Тухайлбал:

- Олон түмнээр тоглож, тэдний зөвхөн сонсохыг хүссэн зүйлийг яригчид.
- “Ард түмэн дунд явагчид” (улс орны өнцөг булан бүрт цаг үргэлж хүрч үйлчлэн, тэдний дуу хоолойг сонсох).
- “Ардын дипломат” (гадаадын улс орнуудад оршин суугаа өөрийн улсын иргэдийн дуу хойлойг сонсож, тэднээр дэмжүүлэх).
- Шийдвэртэй, өөртөө итгэлтэй улс төрчийн дүр бүрдүүлэгчид.

• Уран илтгэх чадвар, өөрийн хөтөлбөрөө богино бөгөөд үр ашигтайгаар танилцуулах чадвар бүхий улс төрчид.

• “Би яг л та нар шиг хүн гэж” ард түмний дундаас төрсөн хүний дүр эсгэгчид.

• Олон нийтийн мэдээллийн хэрэгслийн тусламжтайгаар сэтгэл татам дүр бүтээгчид.

• Ард түмний үндэсний болон эх оронч сэтгэхүйг ашиглагчид.

• Нэртэй хүмүүс, урлагийн “од” жүжигчдийн зүгээс дэмжүүлж байгаагаар харагдагчид.

• Урьд өмнө өөрийн бүтээсэн нэр хүнд дээр дулдуйдан улс төрийн тавцан руу тэмүүлэгчид.

Үндэсний популизмын аргууд



-Хүмүүсийн үндэсний сэтгэхүй мэдрэмжид хандах.

-Шашныг тухайн үндэстний өвөрмөц онцлог байдлаар ашиглах.

-Үндэстний хувьд сайхан санагддаг өнгөрсөн түүхэн үед нь хандах.

-Ёс заншил, уламжлал, шүтлэг, нандин дурсгалыг зусардан магтах.

-Туг, төрийн сүлд, төрийн дуулал, баатрууд зэрэг үндэсний бэлэг тэмдгийг өргөмжлөн магтах.

-Төрөлх хэлний статус нэр хүндийг тухайн нутаг дэвсгэр дээр оршин амьдарч байгаа үндэстний хувьд цорын ганц улсын хэл гэж тодорхойлох.

-Хүмүүсийн үндэсний бахархлыг ашиг хонжооны зорилгод ашиглах.

-“Үндэстний дайсныг” эрж хайх, тэдэнтэй тэмцэх.

ДҮГНЭЛТ

XIX зууны сүүлчээр нийгмийн хөдөлгөөн, үзэл суртал, улс төрийн үйл ажиллагааны төрөл болох утгаар үүссэн популизм нь улс орон бүрийн түүхийн хөгжлийн явцад олон үе шатыг туулж өнгөрүүлэн, шинэ шинэ шинж чанарыг бий болгож, олон түмний улс төрийн ухамсарт хүчтэй нөлөөлж, өөрийн байр сууриа тогтоосоор ирсэн юм.

Ардчиллын дагалдагч шинж тэмдэг болохын хувьд популизм нь өөрийн давалгаагаар улс төрийн лидерүүдийг засаглал, эрх мэдэлд хүргэдэг, гэвч цаашдын улс төрийн үйл ажиллагаандаа эдгээр лидер захиргаадалтын зарчмыг хэрэгжүүлдэг.

Орчин үеийн улс төрийн амьдралд аливаа олны танил улс төрч нь ямарваа нэгэн популист аргыг хэрэглэх, эрх мэдэл, засгийн эрхэнд гарах тэмцэлдээ тодорхой улс төрийн хэв маягийг баримтлахаас өөр аргагүй, учир нь сонгогчдын хэрэгцээ, сонирхлыг бүрэн хэрэгсэхгүй байх нь сонгуульд ялагдахад хүргэнэ.

Өөрөөр хэлбэл, улс төрийн тавцанд Популизм заавал байх ёстой үзэгдэл юм.

ЭХ СУРВАЛЖИЙН ЖАГСААЛТ

1.Ц.Ганболд. Улс төрийн сэтгэл судлал ба хүчирхийллийн сэтгэл зүй. УБ., 2004.

2.Ц.Мөнхцэцэг. Политайнмент буюу цэнгээнт улс төр. УБ., 2010.

3.Хосе Ортега-и-Гассет. Түмний түрэлт. Орч. Ч.Энхээ. УБ., 2001.

4.Populism: Its Meanings and National Characteristics. Ed. by Ionescu G., Gellner E. L., 1969.

5.Ionescu G., Gellner E. Introduction. In: Populism: Its Meanings and National Characteristics. L., 1969.

6.Политология: Энциклопедический словарь. М., 1993.

**Уншиж танилцан нийтлэхийг
зөвшөөрсөн, Сэтгүүлийн
зөвлөлийн гишүүн, хууль зүйн
доктор, цагдаагийн дэд хурандаа
Ш.Ариунбилэг**